| 4.7.5 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх | Үйл ажиллагааны зардлаар | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | - | Бодит, үр дүнтэй, бүтээмжтэй арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэх | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" УИХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд тус тогтоолын 2-р заалтаар арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хэрэгжилтийг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Авлигатай тэмцэх газарт тус тус тайлагнаж ажиллахыг нийт төрийн байгууллагуудад үүрэг болгосон. Энэ хүрээнд тус төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн тайланг нийт төрийн байгууллагуудаас http://khutulbur.iaac.mn/ цахим системд тайлагнасан. Тус тайланд ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргаас өгсөн үүргийн дагуу ДШДАХ-ийн 3 референт АТГ-ын албан хаагчидтай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн. Тус хэлтсээс Засгийн газрын 89 байгууллагаас хариуцсан бүх арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж http://khutulbur.iaac.mn/ цахим системд оруулав. Тус төлөвлөгөөнд тусгагдсан ЗГХЭГ-т хамааралтай 34 заалтын хэрэгжилтийг газар, нэгжүүдээс авч нэгтгэн ХШҮ хийж АТГ-ын цахим системд тайлагнасан бөгөөд эдгээр заалтаас ЗГХЭГ-т хамааралгүй 14 заалтыг хяналтаас хасуулах саналыг өгч шийдвэхрлүүлэв. | 100 |
| 4.7.6 | Байгууллагын хэмжээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын цогц "smart" нэгдсэн системийг нэвтрүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Хяналт, шинжилгээ, үнэлгээний ажил цахим болох | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээний жишиг цахим системийг нэвтрүүлж ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн байна. | -2025 оны 1 дүгээр сар болон 1 дүгээр улирлын тайланг хүлээн авахтай холбогдуулан ЗГХЭГ-ын дотоод нэгжүүдийг "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан /unelgee.gov.mn/"-д холбож, ЗГХЭГ-ын холбогдох албан хаагчидад зааварчилгаа, зөвлөгөө өгөх ажлыг тухай бүр зохион байгуулж, холбогдох албан хаагчдад эрх нээх, системд үүссэн асуудлыг тухай бүр нь | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохицуулан хэвийн ажиллагааг хангаж ажиллав.<br>-ЗГХЭГ-ын дотоод тайлан мэдээний урсгалыг цэгцэлж бүрэн цахимжуулах талаар уг системийг хөгжүүлэгч компанитай Дэд дарга Б.Саруул, ЦЗМТГ-ын дарга Б.Билэгдэмбэрэл болон ДШДАХ-ийн дарга нартай уулзуулж ЗГХЭГ-ын дотоод тайлан мэдээг /cabinet.igovernment.mn/ цахим системээр авч нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн болно. | |
| Стратегийн 5 дугаар зорилго: Цахим засаглал хөгжүүлэх, төрийн үйлчилгээг цахимжуулах, дижитал шилжилт хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, Засгийн газар, ЗГХЭГ-ын цахим систем, цахим хуудас, сүлжээ, компьютер, техник, тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаа, Засгийн газрын хуралдааны цахим систем, танхимын сүлжээ, тоног төхөөрөмж, цахим хурлын бэлэн байдлыг хангах | | | | | | | |
| Зорилт 5.1 | Засгийн газар, ЗГХЭГ-ын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар дижитал шилжилт хийх, Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагааны зардал болон “Ухаалаг засаг-2” төслийн санхүүжилт | Шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байх | Удирдлагын түвшинд шаардлагатай мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. | Удирдлагыг харилцаа холбоо, мэдээлийн технологийн салбарын болон дэвшилтэт технологи ашиглах, холбогдох шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлсэн байна. | -Удирдлагыг харилцаа холбоо, мэдээлийн технологийн салбарын болон дэвшилтэт технологи ашиглах, холбогдох шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлсэн.<br>-Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд “Цаасгүй засаг” арга хэмжээний хэрэгжилтийн талаар ЗГ-ын 2025.01.08-ны өдрийн хуралдаанд танилцуулав. Хуралдааны тэмдэглэлээр “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”-ыг шинэчлэн боловсруулахыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд үүрэг болгосны дагуу ЗГ-ын 2025 оны 126 дугаар тогтоолоор журамд цахим тамга ашиглах тухай өөрчлөлтийг нэмж тусгав.<br>-ЗГ-ын 2025.03.26-ны ээлжит хуралдаанд “Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар” танилцуулга бэлтгэж танилцуулав. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -2025 оныг нийслэлийн дэд бүтцийг хөгжүүлэх жил болгон зарласантай холбогдуулан Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, түүний хэрэгжилтийн тайланг дотоод удирдлагын системээр дамжуулан ЗГ-ын гишүүдийн ашигладаг айпад төхөөрөмжид суурилуулсан “Үүрэг даалгавар” системээр авах боломж бүрдүүлсэн тухай ЗГХ-нд танилцуулав. | |
| 5.1.1 | Засгийн газрын шийдвэрийн цахим систем болон цахим архивын систем хөгжүүлэх, архивын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх арга хэмжээ авах | “Ухаалаг засаг-2” төслийн санхүүжилт | Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд суулгасан байх | “Ухаалаг засаг-2” төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЗГХЭГ-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг багцалж тусгасан. | Систем хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийсэн байна. | ЗГ-ын архивын тоног төхөөрөмж шинэчлэх, Засгийн газрын цахим архивын систем хөгжүүлж нэвтрүүлэх, Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж нэвтрүүлэх ажлуудын ажлын даалгаврыг боловсруулж ТХН, Дэлхийн банкинд хүргүүлсэн. | 100 |
| 5.1.2 | “Ухаалаг засаг-2” төслийн хүрээнд ЗГХЭГ-аас хэрэгжүүлэх төслийн санал, баримт бичиг боловсруулах | | Төслийн санал, баримт бичиг боловсруулсан байх | “Ухаалаг засаг-2” төсөл хэрэгжиж эхэлсэн. | Төслийн 2024 оны ХАА-ны төлөвлөгөөнд ЗГХЭГ-аас хэрэгжүүлэх төслийн санал боловсруулж, ТУХ-нд танилцуулж, батлагдсан төслийн баримт бичиг боловсруулсан байна. | -“Ухаалаг засаг-2” төслийн хүрээнд ЗГХЭГ-аас хэрэгжүүлэх нийт 12 төслийн саналыг боловсруулж ЦХИХХЯ-нд хүргүүлсэн.<br>-Ухаалаг засаг-2 төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЗГХЭГ-аас хэрэгжүүлэхээр санал болгосон 12 төслийг суулгаж, батлуулсан. Нийт 7 төслийн ажлын даалгавар боловсруулж ЦХИХХЯ, Дэлхийн банкинд хүргүүлсэн бөгөөд 4 ажлын даалгавар батлагдаж, 1 төслийн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байгаа бөгөөд 3 ажлын даалгавар техникийн хяналт хийгдэж байна. Үүнд:<br>1. ЗГ-ын архивын тоног төхөөрөмж шинэчлэх (сонгон шалгаруулалт хийгдэж байна)<br>2. ЗГ-ын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлэх, дагалдах тоног төхөөрөмжийн хамт (ажлын даалгавар батлагдсан, худалдан авах ажиллагааны баримт бичиг боловсруулагдаж байна) | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. ЗГ-ын шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлэх, дагалдах тоног төхөөрөмжийн хамт (техникийн хяналт хийгдэж байна)<br>4. ЗГХЭГ-ын үйл ажиллагааг цахимжуулах, дижитал шилжилт хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх (техникийн хяналт хийгдэж байна)<br>5. ЗГ-ын цахим хурлын системийг шинэчлэх, лиценз худалдан авах (ажлын даалгавар батлагдсан, худалдан авах ажиллагааны баримт бичиг боловсруулагдаж байна)<br>6. ЗГХ-ны аудио бичлэгийг текст хэлбэрт хөрвүүлэх цахим систем нэвтрүүлэхэд шаардлагатай программ хангамжийн лицензийн эрх худалдан авах, суурилуулалт хийх (ажлын даалгавар батлагдсан, худалдан авах ажиллагааны баримт бичиг боловсруулагдаж байна)<br><br>-"Төрийн албан хаагчийн сургалтын нэгдсэн цахим платформ-surgalt.gov.mn"-ийг өргөтгөн хөгжүүлэх, сайжруулалт хийх (техникийн хяналт хийгдэж байна) | |
| 5.1.3 | Албан бичиг цахимаар солилцох нөхцөлийг бүрдүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Албан хэрэг хөтлөлтийн DOCX системээр албан бичгийг цахимаар солилцох нөхцөлийг бүрдүүлсэн байх | ХЭГ-ын албан бичгийн систем DOCX системтэй холбогдсон. | “Төрийн албан бичиг солилцооны дундын систем – DOCX”-д холбогдож, албан бичиг цахимаар солилцох нөхцөл бүрдсэн байна. | -ЗГХЭГ-ын дотоод удирдлагын цахим системийн шинэчлэл хийсэнтэй холбогдлуулан шинэ системийг “Төрийн албан бичиг солилцооны дундын систем DOCX”-д холбогдож ажиллах хэвийн нөхцөлийг хангаж ажилласан бөгөөд 2025.06.09-ний өдрийн байдлаар 4960 албан бичгийг цахимаар хүлээн авч, 1850 албан бичиг цахимаар илгээсэн байна.<br>-Системүүдийн холболт хэвийн ажиллаж, албан бичгийг цахимаар солилцох үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.4 | Засгийн газрын хуралдааны цахим системийн шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Системийн шинэчилсэн хувилбар нэвтэрсэн байх | Шинэ системийн хөгжүүлэлт дууссан. | ЗГХ-ны цахим системийн тест хийж суурилуулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Засгийн газрын хуралдааны цахим системийн байнгын ажиллагааг хангаж, нийт 26 хуралдааны үйл ажиллагааг цахим систем ашиглан зохион байгуулж, хуралдааны 646 асуудлын материал, 281 тогтоол, 436 тэмдэглэл, 99 Ерөнхий сайдын захирамжийг цахимаар 111 байгууллагын 185 хэрэглэгчид цахимаар хүргэж, системд дараах нэмэлт өөрчлөлт, сайжруулалтыг хийж, нэвтрүүлсэн:<br>- ЗГХЭГ-ын хуралдаанд асуудал хариуцаж оруулсан ажилтанд хуралдааны асуудал, шийдвэрийг харуулах.<br>- Засгийн газрын хуралдаанд асуудал хариуцаж оруулах ажилтан тухайн асуудлын мэдээллийг системд бүртгэж оруулах.<br>- Шийдвэр хүлээн авах байгууллагын ажилтнуудад тухайн шийдвэрийг илгээсэн, танилцсан огноог харуулах.<br>- Шийдвэр тараалтын хуудсыг системээс хэвлэх.<br>- Засгийн газрын хуралдаанд ороогүй гарсан шийдвэрийг системд бүртгэх.<br>- Шийдвэр анх бүртгэхэд шаарддаг байсан зарим талбар утгуудыг дараа нөхөж бүртгэх боломжтой болгох.<br>- Засгийн газрын хуралдааны төлөвлөгөө батлагдаж, хурал зарлах үйлдэл хийсний дараа хуралдааны мэдээллийг харуулдаг байх.<br>- Шийдвэрийг илгээсэн байгууллагаар шүүж харах.<br>- Шийдвэр дээр асуудал хариуцсан ажилтан, боловсруулсан ажилтан, харах ажилтан нэмэх, бүртгэгдсэн ажилтанд харагддаг байх.<br>- Шийдвэр илгээхэд хэрэглэгчид илгээдэг цахим шууданд тухайн шийдвэртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг харуулдаг байх. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Шийдвэр цахимаар хүлээн авахад шаардлагатай яамдын ТНБД, бичиг хэргийн ажилтнуудыг системд бүртгэх тухай ХЭГ/ 424 тоот албан бичиг боловсруулж, яамдуудад явуулсан бөгөөд холбогдох бүртгэлийг хийж, систем ашиглах зааврыг цахимаар өгсөн.<br>- Их өгөгдөлд суурилсэн нэгдсэн мэдээллийн системтэй холбож, ЗГХЭГ-ын удирдлагууд болон нийт ажилтнууд мэдээллийг харах боломжтойгоор систем хоорондын холболтыг болон байгууллагын дотоод удирдлагын цахим системийн өөрчлөлттэй холбоотой систем хоорондын холболтыг тус тус хийж гүйцэтгэсэн байна. | |
| Зорилт 5.2 | Засгийн газар, ЗГХЭГ-ын цахим систем, сүлжээ, компьютер, техник тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаа, Засгийн газрын хуралдааны танхим, цахим хурлын бэлэн байдлыг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаа хангагдсан байх | Мэдээллийн систем, сүлжээ, тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаа хангагдсан. | Мэдээллийн систем, Интернэт, дотоод, утасгүй сүлжээ, компьютер, тоног төхөөрөмж, программ хангамжийн хэвийн ажиллагааг хангасан байна. | Мэдээллийн систем, Интернэт, дотоод, утасгүй сүлжээ, компьютер, тоног төхөөрөмж, программ хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. | 100 |
| 5.2.1 | Байгууллагын дотоод удирдлагын систем (www.digital.gov.mn)-ийн хэвийн ажиллагааг хангах, системийг удирдан зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Системийн хэвийн ажиллагаа хангагдсан байх | Систем нэвтрүүлж, ашиглалтад оруулсан. | Системийн байнгын, хэвийн ажиллагааг хангах, алдаа засварлах, хөгжүүлэлт хийх, цахим орчинд ажиллах боломжийг бүрдүүлсэн байна. | Байгууллагын дотоод удирдлагын “Дижитал оффис” цахим системийг өөрчилж, системийн хэвийн ажиллагааг хангаж, байгууллагын үйл ажиллагааг цахимаар явуулах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:<br>- Систем өөрчилсөнтэй холбогдуулан “Үндэсний дата төв” дээрх сүлжээний холболт, сервер дээрх тохиргоо, домэйн хаягийн шилжилт, системийн тохиргоо хийх ажлыг ҮДТ УТҮГ, Интерактив ХХК, Able ХХК-тай хамтран гүйцэтгэж, хуучин болон шинэ системийг тасалдалгүй ажиллах, систем хоорондын шилжилтийг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>- Системийн шилжилттэй холбоотой Хүний нөөцийн мэдээллийн санг хөрвүүлж оруулах, | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | системийн хэрэглэгч үүсгэх, системд хандах эрх тохируулах ажлыг системд тасалдал үүсэхгүйгээр хийж гүйцэтгэсэн.<br>- Цаг бүртгэлийн модуль дээр цаг бүртгэлийн төхөөрөмжөөс цаг татах, бодолт хийх, ажлаас гарсан болон орсон ажилтнуудын холболтыг тухай бүр хийх, удирдлагуудад эрхийн тохиргоо үүсгэх, цагийг системээр болон гар утаснаас бүртгүүлэхэд шаардлагатай тохиргоог тухай бүр хийж гүйцэтгэсэн.<br>- ЗГХ-ны цахим системийг Able системтэй холбох хөгжүүлэлтийг хийж, 2 систем холбогдож ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>- Able системийн баримт бичиг модулийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, цахимаар албан бичиг солилцох нөхцөлийг бүрдүүлж, байнгын ажиллагааг хангасан.<br>- Албан бичиг модулийн бичиг хэргийн ажилтнууд болон даргын туслах ажилтнуудын холбогдох тохиргоог хийж, Албан бичиг модулийг удирдах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>- Хүний нөөцийн модуль дээр системийн хандалтын эрх, ажилтны бүртгэлийн үндсэн өгөгдөл, хөтлөн удирдах эрх, өгөгдөл хариуцагч шилжүүлэхэд шаардлагатай өөрчлөлт, нэмэлт сайжруулалтыг хийсэн.<br>- Цаг бүртгэлийн модуль дээр сүлжээний хаяг, байршил тодорхойлох, хүсэлт илгээх эхлэх, дуусах цаг тодорхойлох, хариуцагч тодорхойлох, ажилтан, газар хэлтсийн харьяалал тогтоох зэрэг сайжруулалт, тохиргоог гүйцэтгэсэн.<br>- Ажил хэрэг модуль дээр Ерөнхий сайд, Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар бүртгэхэд шаардлагатай Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг бүртгэх, байгууллагын харъяалал | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоох, шилжилт хийхэд шаардлагатай тохиргоог хийсэн.<br>- Албан бичиг модуль дээр Шинэ бичиг төлөвлөлт хийх модулийг нэвтрүүлж, бланк үүсгэх, загвар үүсгэх, ажлын урсгалыг тогтооход шаардлагатай тохиргоонуудыг хийж бичиг төлөвлөлтийг цахимаар хийх нөхцөл бүрдүүлсэн.<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хамт олны үнэлгээг цахимаар хийх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>Систем хоорондын шилжилтийг хийж, шинэ систем нэвтрүүлж, байнгын ажиллагааг хангах, хуучин системийг архивын төлөвт шилжүүлэх ажлыг тасалдал үүсэхгүй хийж, байгууллагын үйл ажиллагаа цахимаар хийгдэх нөхцөлийг хангаж ажилласан. | |
| 5.2.2 | ЗГХЭГ-ын дотоод, утасгүй, интернэт сүлжээг удирдан зохион байгуулах, аюулгүй, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Байнгын, хэвийн ажиллагаа хангагдсан байх | Байнгын ажиллагаа хангагдсан. | Ажиллагааны хяналтыг тогтмол хийж, аюулгүй байдлыг хангах, сүлжээний хаягжилтыг шинэчлэх, сүлжээний тасралтгүй, байнгын ажиллагааг хангасан байна. | Сүлжээний байнгын, хэвийн ажиллагааг хангаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:<br>- Интернэт сүлжээний хяналт удирдлагын LibreNMS мониторинг систем дээр сүлжээний урсгал, тоног төхөөрөмж дээрх дотоод сүлжээний хяналтыг хийж ажилласан.<br>- Сүлжээний аюулгүй байдлын галт хана Checkpoint 5600, Checkpoint smart-1 600-S management, FortiGate F80, Cisco 2960X сүлжээний свич нийт 12 төхөөрөмжийн системийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан.<br>- Нийслэлийн төр захиргааны I байранд нэмж 2ш FortiAP утасгүй сүлжээ үүсгэгч төхөөрөмжийг тохируулан суурилуулсан.<br>- Утасгүй сүлжээний 31 ширхэг CISCO болон 6 ширхэг Fortinet Access point Wi-Fi төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, Wireless Controller дээр хяналтыг хийж VIP, Cabinet VIP, CSGM, CSGM2 нэртэй утасгүй сүлжээг тус тус үүсгэн ашиглаж байна. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2.3 | УИХ-ын IPTV болон Univision IPTV үйлчилгээнд холбогдсон хэрэглэгчийн үйлчилгээг тасралтгүй хангах, үйлчилгээний гэрээ, төлбөр төлөлтийг хянах, өрөө солигдсон бол шинээр холбогдох хэрэглэгчийн холболтыг хийх, байнгын, хэвийн ажиллагааг хангах, ашиглалтын заавар зөвлөгөө өгөх | Үйл ажиллагааны зардлаар | IPTV үйлчилгээний байнгын, хэвийн ажиллагаа хангагдсан байх | Сүлжээний холболт хийгдэж, 40 хэрэглэгч холбогдсон. | Хэрэглэгчийн үйлчилгээг тасралтгүй хангаж, үйлчилгээний гэрээ, төлбөр төлөлтийг хянах, байнгын, хэвийн ажиллагааг хангах, ашиглалтын заавар, зөвлөгөө өгсөн байна. | УИХ-ын IPTV үйлчилгээ 2025 оны 05 дугаар сараас UNIVISION IPTV үйлчилгээ рүү шилжсэнтэй холбогдуулан хуучин 14 хэрэглэгчийн төхөөрөмжийг хураан авсан. Юнивишн ХХК-тай 2025.05.27-ны өдрийн 25/188 тоот гэрээгээр IPTV үйлчилгээний төхөөрөмжийг нэмэгдүүлэн 50ш болгон гэрээг шинэчлэн байгуулсан. Үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг холбогдох байгууллагаас авч СХОГ-т шилжүүлж, төлбөрийг тухай бүр гүйцэтгэсэн. Хэрэглэгчийн IPTV үйлчилгээ хэвийн, тасралтгүй ажиллаж байна. | 100 |
| 5.2.4 | Засгийн газрын хуралдааны сүлжээ, тоног төхөөрөмж, хуралдааны үеэр ашиглагдах систем, программ хангамжийн хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Техник тоног төхөөрөмж, сүлжээ, програм хангамжийн хэвийн ажиллагаа хангагдсан байх | Техник, тоног төхөөрөмж, сүлжээний холболт хийгдэж, системүүдийг ашиглалтад оруулсан. | Танхимын сүлжээ, техник тоног төхөөрөмж, системийн бэлэн байдлыг хангасан хийсэн байна. | - Засгийн газрын ээлжит болон ээлжит бус 26 удаагийн хуралдаанд интернэт сүлжээний 3 төхөөрөмж, дүрст хурлын төхөөрөмж, сервер компьютер 1, хэрэглэгчийн 35 компьютерын тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажилласан.<br>- ТТХГ-ын Тусгай холбооны хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран дуу, дүрсний микрофон болон техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажилласан.<br>Хуралдааны танхимын суурин болон зөөврийн компьютерын үйлдлийн систем, веб хөтөч програмын шинэчлэлтийг тогтмол хийж дэлгэцийн зургийг нэг ижил болгон тохируулсан.<br>- ЗГ-ын ээлжит болон ээлжит бус 26 удаагийн хуралдаанд www.digital.gov.mn, www.e-cabinet.gov.mn хурлын систем, сайд нарын таблетын e-cabinet программын бэлэн байдлыг хангаж ЗГХ-нд асгийн газрын хуралд танилцуулагдсан 150 гаруй танилцуулгын формат, дуу дүрсийг шалгаж тоглуулсан. Хурал сайдын нарын асуулт, санал хэлэхэд “3 мин” хугацааны программ хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажилласан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - ЗГХ-нд танилцуулагдсан танилцуулга материалын сан үүсгэж тухай бүр нь файл серверт хуулж архив үүсгэн ажилласан.<br>- ЗГХ-ны танхимын сайд нарын компьютер болон сервер компьютерт “screenmirroring” системээр дамжуулан танилцуулга харах, удирдах боломжоор хангасан. | |
| 5.2.5 | Ерөнхий сайдын ажлын алба, Шадар сайдын ажлын алба, ЗГХЭГ-ын ажилтнуудын ашиглалтад байгаа компьютер, принтер, сканнер болон бусад дагалдах тоног төхөөрөмж, албаны цахим шуудангийн (@cabinet.gov.mn) байнгын хэвийн ажиллагааг хангаж, албан ёсны лицензтэй оффисын болон вирусны эсрэг программ хангамжийг суурилуулж, хэвийн ажиллуулах | Үйл ажиллагааны зардлаар | Компьютер, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн хэвийн ажиллагаа хангагдсан байх | Ажилтан бүрийн компьютер, принтер болон бусад төхөөрөмж, программ хангамжийн хэвийн ажиллагаа хангагдсан. | Техник, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, программ хангамж суурилуулах, шинэчлэх, ашиглалтын заавар зөвлөгөөг тухай бүр өгч, эвдрэл гэмтлийг оношилж засварласан байна. | - Албан хаагчдын компьютер, принтер, сканер, зөөврийн төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийн оношлох, засварлах ажлыг тухай бүр гүйцэтгэж, ашиглалтын заавар зөвлөгөө өгсөн.<br>- Шинээр худалдан авсан суурин болон зөөврийн компьютерт хэрэглээний программ хангамж суулган ажилтнуудад өгч хуучин компьютеруудыг хураан авч, үйлдлийн систем, программ хангамжийг шинээр суулган дараагийн хэрэгчид суурилуулах ажлыг гүйцэтгэсэн.<br>- Ашиглагдахгүй байгаа 2012-2017 оны 15ш iMac компьютеруудыг нэг бүрчлэн үзүүлэлт, огноог нь шалган бүртгэж, форматласан.<br>- Вирусийн эсрэг BitDefender программ хангамжийг 200 хэрэглэгчийн албан ёсны эрхийг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 25/78 дугаар гэрээгээр худалдан авч ЗГХЭГ-ын нийт ажилтнуудын компьютер, зөөврийн төхөөрөмж дээр суулгаж, программ хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.<br>- Вирусийн эсрэг программ хангамжийн лицензийн хугацааг сунгах болон өөр программ хангамжаар шинэчлэх талаар холбогдох судалгааг хийж, Тагнуулын ерөнхий газраас холбогдох зөвлөмжийг авч ажилласан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2.6 | Цахим хурал болон бусад ажлын хэсгийн хурлын техникийн бэлэн байдлыг хангаж, дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Цахим хурал, ажлын хэсгийн хурлын бэлэн байдал хангагдсан байх | Цахим хурлын систем нэвтрүүлсэн. | ЗГХЭГ-ын цахим хурлын систем (www.econf.gov.mn)-ийн хэвийн ажиллагааг хангаж, хурал зохион байгуулах, ажлын хэсгийн хурлын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан байна. | - ЗГХЭГ-ын цахим хурлын (www.econf.gov.mn) системийг ашиглан Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ-ын нэгжүүд 23 удаагийн цахим хурал хийгдсэнээс давхардсан тоогоор 528 гаруй оролцогч оролцсон байна. ЕТГ, Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ-ын нэгжүүд Нутгийн удирдлагын танхимд 167 хурлын техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаан ажилласан.<br>- Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/-ын албан өрөөнд дүрст хурлын нэгдсэн систем болон гамшгийн үеийн мэдээллийг хүргэх системийг суурилуулах, туршилт хийх ажлыг ТЕГ, Онцгой байдлын ерөнхий газар болон ТТХГ-ын Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн ажилтнуудтай хамтран 2025 оны 04 сард хийсэн.<br>- 23 сайдын iPad төхөөрөмжид Trueconf хурлын систем суурилуулан, тохируулга хийснээр ЗГ-ын гишүүд хоорондоо дүрст хурал хийх боломжийг бүрдүүлсэн. | 100 |
| 5.2.7 | Цаг бүртгэлийн төхөөрөмжийн байнгын, хэвийн ажиллагааг хангаж, шинээр ажилд орсон ажилтнуудын үнэмлэхийг бүртгэх, ажлаас гарсан ажилтнуудын үнэмлэхийг бүртгэлээс хасах, дотоод удирдлагын “Дижитал оффис”-ын системд холболтыг хийж, мэдээллээр хангах | Үйл ажиллагааны зардлаар | Төхөөрөмжийн байнгын, хэвийн ажиллагаа хангагдсан байх | Төхөөрөмж, системийг суурилуулж, ашиглалтад оруулсан. | Цаг бүртгэлийн төхөөрөмжийн байнгын ажиллагааг хангасан байна. | - Шинээр ажилд орсон ЗГХЭГ-ын ажилтнуудад цаг бүртгэлийн ID Card нээж, эрхийг тохиргоог хийж, дотоод удирдлагын системтэй холболт хийн хэвийн ажилгааг хангаан ажиллаж байна.<br>- Ажлаас гарсан, алдагдсан үнэмлэхүүдийг тухай бүрт “Lost” төлөв- рүү шилжүүлсэн болно.<br>- Пластик үнэмлэх шинээр 64 ширхэг, цаасан үнэмлэх 234 цаасан үнэмлэх нэмж хэвлэсэн байна.<br>Цаг бүртгэлийн программыг амжилттай дотоод удирдлагын “Дижитал оффис”-ын систем рүү шилжүүлээд байна. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 5.3 | Мэдээллийн ил тод байдал, вэб сайтын байнгын ажиллагааг хангаж, иргэд олон нийтэд нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх | Үйл ажиллагааны зардлаар | Вэб сайтын байнгын ажиллагаа, мэдээ мэдээлэл | Байнгын ажиллагаа хангагдсан. | Вэб сайтын байнгын ажиллагаар хангаж, мэдээ мэдээллээр баяжуулсан байна. | Вэб сайтын байнгын ажиллагаар хангаж, мэдээ мэдээлээр баяжуулсан. | 90 |
| 5.3.1 | ЗГХЭГ-ын вэбсайт (www.cabinet.gov.mn), Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн портал (www.khural.mn)-ын байнгын хэвийн ажиллагаар хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээ, мэдээллээр баяжуулах, ил тод байдлыг хангах, холбогдох аюулгүй байдлын арга хэмжээг авах, технологийн сайжруулалт хийх | Үйл ажиллагааны зардлаар | Цахим хуудасны байнгын ажиллагаа хангагдаж, мэдээ мэдээлэл нийтэлсэн байх | Цахим хуудасны шинэчлэл хийгдсэн, хэвийн, аюулгүй ажиллагаа хангагдсан. | Цахим хуудасны байнгын, хэвийн, аюулгүй ажиллагаар хангаж, мэдээ мэдээллийн шинэчлэл хийх, мэдээлэл оруулах, иргэдийг ил тод, нээлттэй мэдээллээр хангах, бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх. Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээллийг байршуулсан байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгах хүрээнд өөрийн эрх хэмжээнд хамааралтай мэдээ, мэдээллийг ЗГХЭГ-ын вэбсайт (www.cabinet.gov.mn)-аар олон нийтэд мэдээлж ажиллалаа. 2025 оны эхний хагас жилийн байдлаар цаг үеийн шинжтэй, үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын 51 гаруй мэдээ, мэдээллийг байршуулж, иргэдэд мэдээлэл хүргэсэн. Нээлттэй мэдээллийг I улиралын байдлаар (www.shilen.gov.mn) цахим системд байршуулсан болно. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын (www.khural.mn)-цахим систем нь хэвийн ажиллаж байна. Мөн khural.mn домайн эрхийг сунгах ажлыг зохион байгуулсан. Уг системд нэмэлт хөгжүүлэлт хийх шаардлагатай байгаа талаар Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газар, Онлайнсолюшнс ХХК-тай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. ИТ-ийн хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх нь ЗГХЭГ-ын даргын чиг үүрэгд хамаардаг тул хүлээлгэн өгөх тухай ХЭГ/1574 тоот албан бичгийг УИХТГ-т хүргүүлсэн. | 80 |
| 5.3.2 | Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн системийн хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Хэвийн ажиллагаа хангагдсан байх | Системийг суурилуулж хэвийн ажиллагаар хангасан. | Хэвийн ажиллагаар хангаж, хөгжүүлэлтийг хийсэн байна. | -Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн интернэт болон дотоод сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаар хангаж ажилласан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Утасгүй сүлжээний 11-11 office, 11-11 User тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангасан.<br>-Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн операторуудын засвар, үйлчилгээний дуудлагыг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн.<br>-Операторуудын суурин компьютерын санах ой, хатуу дискийн хурд, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх ажлыг хийж ажилласан.<br>Сүлжээ, компьютер тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байна. | |
| Стратегийн 6 дугаар зорилго: Төрийн албаны хүний нөөцийн бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж, төрийн бүтээмж, үйл ажиллагааг сайжруулах | | | | | | | |
| Зорилт 6.1 | Төрийн албаны хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Үйл ажиллагааны зардлаар | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 50% | Тус зорилтын хүрээнд 7 арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн. | 95 |
| 6.1.1 | Чадахуйн зарчимд суурилсан оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулж, иргэнд ойр төрийн албыг бий болгох чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийхэд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, санал боловсруулах | Үйл ажиллагааны зардлаар | Үнэлгээний тайлан, судалгааны тоо | - | 5 | Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулах Ажлын хэсгийг ЗГХЭГ-ын ТДД-ын 2024 оны 309 дугаар тушаалаар байгуулагдсан. Тус үнэлгээг хийхдээ 16 яам, аймаг, нийслэлийн 24 төрийн захиргааны байгууллагын 20041 албан хаагчаас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль хэрэгжиж эхэлснээс хойш ямар түвшинд хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжилтийг хангахад гарах хүндрэл бэрхшээл болон бусад хууль тогтоомжтой уялдах, давхардах, зөрчилдөж байгаа эсэхийг хуулийн 7 хэсэг, 23 бүлгийн 77 зүйл, 467 хэсэг, заалт тус бүрээр тайлбарлах хэлбэрээр үнэлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.6 дахь хэсэгт заасныг удирдлага болгон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг баримтлан Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийлээ. Үнэлгээний үр дүнд Төрийн албаны тухай хуулийн 467 заалтаас хэвээр үлдээх нь 250, нэмэлт, өөрчлөлт оруулах нь 145, үнэлэх боломжгүй нь 46, хүчингүй болгох нь 26 заалт тус тус байна гэж гарсан. Мөн тайланд хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй болгохын тулд Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн найруулах эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар болон хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох шаардлагатай байгаагаас гадна тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан шинэчилсэн найруулга хийх саналыг дэвшүүлсэн.<br><br>Төрийн албаны харилцааг зохицуулж буй журам, дүрмүүдийн өнөөгийн байдлыг үнэлж, сайжруулах боломжит чиглэлүүдийг тодорхойлох зорилгоор ТВI-аас авсан зөвлөмжийн дагуу "Төрийн албатай холбоотой журам, дүрмийн хэрэгжилтийн дүн шинжилгээ" хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулан батлуулав. Ажлын даалгаврын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан 1 журам, УИХ-ын тогтоолоор баталсан 8 журам, дүрэм, Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор баталсан 13 журам, дүрэм, Засгийн газрын тогтоолоор баталсан 18 журам, дүрэм, жагсаалт, аргачлал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар баталсан 3 журмын хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг Судлаач, | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуульч, өмгөөлөгч, хууль зүйн ухааны магистр Р.Хатансайхан гүйцэтгэсэн. Тус тайланг ЗГХЭГ-ын албан хаагчдаар хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. | |
| 6.1.2 | Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | Үйл ажиллагааны зардлаар | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 100% | Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Хорват Улс, Канад улс, Эстони улсын Төрийн албаны тухай хуулийн зохицуулалтын харилцаа, хамрах хүрээ, нэр томьёо, ангиллын талаар харьцуулсан судалгааг хийж, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд хавсаргав хэвлүүлэв.<br>Төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгт дүн шинжилгээ хийх зорилгоор ИБУИНХУ-ын “Tony Blair Institute”-ийн гүйцэтгэсэн “Засгийн газрын бүтээмж ба төрийн үр ашиг” тайланг орчуулж, холбогдох мэдээллийг бэлтгэн удирдлагад танилцуулав.<br><br>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбоотой дараах судалгаа, шинжилгээний ажлын даалгавруудыг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргаар батлуулав. Үүнд:<br>✓ Нийтийн албаны ерөнхий хуулийн хэрэгцээ шаардлагатай холбоотой тооцоо, судалгаа;<br>✓ Төрийн албан хаагчийг бэлтгэх, хүний нөөцийн шилжилт хийх талаар харьцуулсан судалгаа;<br>✓ Улс төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа;<br>✓ Төрийн албаны ангилал тус бүр (төрийн захиргааны, төрийн үйлчилгээний, төрийн | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улс төрийн албан тушаалын)-ээр хийгдэх тооцоо, судалгаа;<br>✓ Төрийн албан хаагчийн тооны зохистой харьцааны судалгаа.<br><br>Дээрхээс Төрийн албан хаагчийг бэлтгэх, хүний нөөцийн шилжилт хийх талаар харьцуулсан судалгаа, Улс төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлсний судалгаа, Төрийн албатай холбоотой журам, дүрмийн хэрэгжилтийн дүн шинжилгээний ажлуудыг хянан хүлээн аваад байна.<br>Төрийн албаны тухай хуулийг шинэчлэх ажлын хүрээнд хийгдсэн “Төрийн захиргааны албаны гүйцэтгэлийн удирдлагын шинэчлэгдсэн процесс”-ын бүдүүвч, схемийн тайлбарыг боловсруулж, хууль тогтоомжид тусгах зохицуулалтын томьёоллыг боловсруулав.<br><br>Төрийн албаны хуулийн шинэчлэлийн хүрээнд судлаачидтай хамтран дараах судалгааг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>✓ Төрийн албан хаагчийг бэлтгэх, хүний нөөцийн шилжилт хийх талаар харьцуулсан судалгаа;<br>✓ Улс төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа;<br>Төрийн тусгай албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа.<br><br>“Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг танилцуулах, төрийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албаны шинэчлэлийн талаар санал солилцох” уулзалт, хэлэлцүүлгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан хаагчдын дунд зохион байгууллаа.<br>“Улс төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа”-ны үр дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан хаагчдын дунд зохион байгуулав.<br>Төрийн албаны шинэчлэлийн асуудлын хүрээнд хийгдэх дараах “Төрийн албаны ангилал, зэрэглэлийг оновчтой болгох асуудлыг хэлэлцэж, шийдэл гаргах” уулзалт, “Нийтийн албаны ерөнхий хуулийн төслийг танилцуулах” уулзалтын хөтөлбөрийг боловсруулж, зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангав.<br><br>БНСУ-ын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-аас хэрэгжүүлж буй “Монгол Улсын төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь төсөл”-ийн хүрээнд ”Гүйцэтгэлийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний гарын авлага” боловсруулах ажлын хүрээнд Удирдлагын академитай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр уулзалт зохион байгуулж, гарын авлагад тусгах шаардлагатай агуулга, шалгуур үзүүлэлт, албан хаагчдыг чадавхжуулах, үр дүнтэй хэрэгжүүлсэн жишээ, баримтыг оруулах талаар санал солилцож, хамтран ажилласан.<br>БНСУ-ын КОЙКА төслийн хүрээнд хэрэгжиж буй Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын систем хөгжүүлэх ажлын хүрээнд нийлүүлэгдэж буй сервер, компьютер, тоног | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжийг хүлээн авах ажлыг Цахим засаглал, мэдээллийн технологийн газрын албан хаагчидтай хамтран зохион байгууллаа. Сервер болон сүлжээний тоног төхөөрөмжийг Үндэсний дата төвд суурилуулах ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллав. Канад–Монголын "Мерит" төсөлтэй төрийн албаны шинэчлэл, төрийн албаны ёс зүйн чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр байгуулав. | |
| Зорилт 6.2 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлж үе шаттай нэвтрүүлэх | Төсөл, хөтөлбөр | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 50% | Тус зорилтын хүрээнд 2 арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн. | 76.3 |
| 6.2.1 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн хөгжүүлэлтийн ажлыг дуусгаж, хүлээн авах ажлыг зохион байгуулах | Төсөл, хөтөлбөр | Систем хөгжүүлэлтийн хувь | 75% | 100% | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний нөөцийн удирдлагын яам хооронд хүний нөөцийн удирдлагын чиглэлд хамтран ажиллах санамж бичгийг 2019 онд байгуулж, БНСУ-ын Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын санхүүжилтээр "Монгол Улсын төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь төсөл" хэрэгжиж байна. Уг төслийн хүрээнд "Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн систем" хөгжүүлэх ажлыг БНСУ-ын талаас Нексин компани хариуцаж, хөгжүүлэгчээр Монголын талаас Спинавэб компани хамтран гүйцэтгэж байна. Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлснээр Засгийн газрын 2023 оны 301 дүгээр журмаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-аар | 76.3 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохицуулж байгаа харилцааг цахимжуулж, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, үнэлгээг үр дүн, нотолгоонд суурилсан, бодитой, шударга байдлаар хийх нөхцөл бүрдэх юм. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газар, Цахим засаглал, мэдээллийн технологийн газар хамтран гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн систем хөгжүүлэлтийн ажлын явцтай танилцаж, тодорхой хүрээнд эхний туршилтыг хийж, сайжруулах ажлын саналыг хөгжүүлэгч талд хүргүүлэн ажиллаж байна. Гүйцэтгэлийн удирдлагын цахим системийн хөгжүүлэгч болон туслан гүйцэтгэгч компанийн төлөөллүүдтэй 7 удаа (танхимаар 5, цахимаар 2)-ийн уулзалтыг зохион байгуулж, ажлын даалгаврын хүрээнд тодруулах шаардлагатай асуудлуудад тухай бүр хариулт өгч зөвлөн тусалж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллаж байна. Мөн БНСУ-ын Нексин компанийн 7 дахь албан томилолтын үеэр буюу 4 сарын 28-наас 5 сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд системийн үндсэн функцүүдийн ажиллагааг тест хийж шалгах, ажлын даалгаврын хүрээнд нэмэлт тодруулга хийх чиглэлээр газрын албан хаагчдыг хамруулсан уулзалтыг зохион байгуулж, ажлын даалгаврын хүрээнд систем хөгжүүлэлтэд зайлшгүй хийж гүйцэтгэх шаардлагатай нийт 131 санал бүхий ажлын жагсаалтыг тодорхойлж, хөгжүүлэгч компанид хүргүүлсэн бөгөөд "Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн систем" хөгжүүлэлтийг Засгийн газрын 2023 оны 301 дүгээр журмаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түвшинг үнэлэх журам"-тай нийцүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгч, туршилт хийж хамтран ажиллаж байна. | |
| 6.2.2 | Гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийг үе шаттай нэвтрүүлэх | - | Систем нэвтрүүлсэн төрийн байгууллагын хувь | - | 30% | Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болоогүй. | - |
| Зорилт 6.3 | Төрийн албаны сургалтын орчин нөхцөлийг сайжруулж, төрийн албан хаагчийг сургаж, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно. | Улсын төсөв, төсөл, хөтөлбөр | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 50% | Тус зорилтын хүрээнд 4 арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн. | 90 |
| 6.3.1 | Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох | - | Боловсруулсан эрх зүйн бичиг баримт бичгийн тоо | - | 1 | Төрийн албаны сургалтын байгууллагын чадавх, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах хүрээнд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 27 тушаалаар "Удирдлагын академийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах" Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хүрээнд Удирдлагын академийн үйл ажиллагаатай танилцаж, сургалтын үйл ажиллагааг илүү оновчтой болгох, тус байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулах чиглэлээр холбогдох санал, дүгнэлтийг боловсруулллаа. Мөн төрийн албаны эрх зүйн шинэчлэлийн хүрээнд төрийн албаны сургалтын байгууллагын статусыг илүү оновчтой болгох саналыг боловсруулан тусгахаар ажиллаж байна.<br><br>Төрийн албаны сургалтын нэгдсэн системийг хөгжүүлэх ажлын хүрээнд Удирдлагын академиас төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар төрийн албаны сургалтын нэгдсэн системийг хөгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. Сургалтын нэгдсэн системийг хөгжүүлэх ажлыг | 80 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Гөүсмарт" ХХК гүйцэтгэхээр шалгарсан бөгөөд тус компани энэ чиглэлээр цахим систем хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. | |
| 6.3.2 | Төрийн албанд үр бүтээлтэй ажилласан албан хаагчийг гадаадад мэргэжил дээшлүүлэх болон ахисан түвшний сургалтад хамруулах | Улсын төсөв, төсөл, хөтөлбөр | Сургалтад хамрагдсан нийт төрийн албан хаагчийн тоо | 50 | 50 | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын 62 албан хаагчийг БНСУ, БНХАУ, БНЭУ-д хүний нөөц, санхүү, гүйцэтгэлийн удирдлагын чиглэлээр богино хугацааны чадавхжуулах сургалтад хамруулав.<br><br>Хөгжлийн эрэлттэй болон тэргүүлэх чиглэлээр төрийн албан хаагчийг гадаад улсад ахисан түвшний сургалтад хамруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг боловсруулан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам"-ын төсөлд тусгаж, Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 |
| Зорилт 6.4 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх | - | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 100 | Тус зорилтын хүрээнд 5 арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн. | 95 |
| 6.4.1 | Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулж, дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж зохион байгуулалтаар хангах | - | Ажлын гүйцэтгэлийн хувь | - | 1 | 1. Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо 2025 оны эхний хагас жилд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой 13 гомдол, мэдээлэл хүлээн авсан. Ёс зүйн дэд хорооны хурлыг 5 удаа зохион байгуулж, 7 гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу хянан шалгаж, холбогдох шийдвэрийг гарган ажилласан. Үүнээс: | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн удирдах албан тушаалтны ёс зүйн асуудалтай холбоотой гомдол, мэдээллийг хянаж шалгах үйл явц, хуралдааныг нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажиллаж, дүгнэлтийн төслийг боловсруулан Ёс зүйн дэд хорооны гишүүд, даргад хянуулж, гомдол гаргагч, гомдол хамаарагчид хууль тогтоомжийн дагуу хүргүүлэв.<br>-Сумын Засаг даргын ёс зүйн асуудалтай холбоотой гомдол, мэдээллийг хянаж шалгах үйл явц, хуралдааныг нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажиллаж, дүгнэлтийн төслийг боловсруулан Ёс зүйн дэд хорооны гишүүд, даргад хянуулж, гомдол гаргагч, гомдол хамаарагчид хууль тогтоомжийн дагуу хүргүүлэв.<br>-Бусад 6 гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж, зарим байгууллагын Ёс зүйн дэд хороонд холбогдох зөвлөмжийг хүргүүлээд байна.<br>-Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны болон 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан, тоон мэдээллийг батлагдсан маягтын дагуу боловсруулж Ёс зүйн дэд хороонд хүргүүлэв.<br>Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын цахим системд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд бүртгэв.<br>-Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт 11 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 1500 гаруй албан хаагчид хамрагдсан бөгөөд яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Агентлагийн дарга, бүх аймгийн сумын Засаг | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дарга нар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол нэгдэл, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдах болон эрх бүхий албан тушаалтнаас гадна Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Зам, тээврийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Барилгын хөгжлийн төв зэрэг байгууллагын албан хаагчид хамрагдсан.<br>-Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2 албан хаагчийг Монгол Улсын Ёс зүйн дэд хороо болон Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан “Ёс зүйн сургагч багш бэлтгэх” хөтөлбөрийн дагуу 4 хоногийн танхимын сургалтад хамруулав. | |
| 6.4.2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах | - | Хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах саналын тоо | - | 1 | -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 8 багц саналыг боловсруулан удирдлагуудад танилцуулж, Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороонд хүргүүлэхээр бэлтгэв.<br>-УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-г хийх гэж байгаатай холбоотойгоор тус хүрээлэнгийн холбогдох албан хаагчидтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулж, холбогдох баримт материалуудаар хангав. Тус үнэлгээний ажилтай холбоотой хийгдэх судалгааны асуулгад санал өгч ажиллалаа. | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний ажил 2025 оны 8 дугаар сараас эхлэн хийгдэх юм. | |
| Зорилт 6.5 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах | - | Ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | Тус зорилтын хүрээнд 8 арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн. | 100 |
| 6.5.1 | Төрийн албаны хүний нөөцтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | Тогтоол, шийдвэрийн тоо | 18 | 21 | -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ургамал хамгааллын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хянуулахаар хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар уг албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж, “Зөвшөөрөл олгох тухай” Төрийн албаны зөвлөлийн 54 дүгээр тогтоолыг ирүүлсэн. Зөвшөөрлийг үндэслэн тус албан тушаалын тодорхойлолтыг батлах Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт боловсруулж, Засгийн газрын 2025 оны 88 дугаар тогтоолоор батлуулсан.<br>-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газрын дарга, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хянуулахаар хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Засгийн газрын тохируулагч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хянуулахаар хүргүүлсэн.<br>-Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хянуулахаар хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар уг албан тушаалын тодорхойлолтуудыг батлах зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж, “Зөвшөөрөл олгох тухай” Төрийн албаны зөвлөлийн 130 дугаар тогтоолыг иргүүлсэн. Зөвшөөрлийг үндэслэн тус албан тушаалын тодорхойлолтыг батлах Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт боловсруулав.<br>-Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Батзандан, Хархорум хотын захирагч Л.Халтар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ж.Бямбасүрэн, Эрчим хүчний зохицуулах хорооны гишүүн Б.Энхжаргал нарын албан тушаалтнуудыг хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>-Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Засгийн газраас нэр дэвшүүлэх нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанаар хэллэлцүүлэх тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулав.<br>-Ерөнхий сайдын захирамжаар томилогдож чөлөөлөгддөг болон Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, 20 минутын хот Үндэсний хороо, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны нийт 150 албан хаагчдын 2025 оны ХАСХОМ-г хуулийн хугацаанд бүрдүүлэн авч, тайланг АТГ-руу хугацаанд нь хүргүүлсэн.<br><br>Дээрх байгууллагуудын болон Эрчист Монгол ТӨХК-ийн ХАСХОМ мэдүүлэх шаардлагатай нийт 55 албан хаагчдын ХАСУМ болон ХАСХОМ-г шинээр мэдүүлэх, хянан баталгаажуулах ажлыг хариуцан гүйцэтгэв.<br>Тайлант хугацаанд 59 албан тушаалтны ХАСУМ-ийн эрхийг системд нээж, мэдүүлгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, хяналт тавин ажиллав.<br><br>-Гаалийн байгууллагын төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтын төслийг Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, танилцуулгын хамт боловсруулж, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.<br>-Төрийн албаны зөвлөлөөс төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмж ирүүлсний дагуу 9 яам, 7 аймгийн Засаг даргын Тамгын газар, 9 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус зөвлөмжийг хүргүүлэх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэв.<br>-Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын сонгон шалгаруулалт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын томилгоотой холбоотой Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмж, мэдэгдлийг хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу хангаж ажиллав.<br>-Төрийн албаны зөвлөлөөс хийсэн “Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвт хүний нөөцийн аудитын тайланд Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулав. Тус зөвлөмжийг холбогдох яамдад хүргүүлэв.<br>-Төрийн дээд шагналд нэр дэвшигч 1094 иргэний материал (15,225 хуудас)-ыг хянаж, Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан. Тухайлбал, ХХМ-574, АГО-288, ХГУТО-121, СБО-3, МУГ-97, Ардын багш-1, Ардын эмч-1, Хөдөлмөрийн баатар-5 байна.<br>-Бүсчилсэн хөгжлийн зорилт, орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэх чиглэлээр үнэтэй санал дэвшүүлж, Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар өргөтгөсөн хуралдаанд манлайлал үзүүлж оролцсон 2 иргэнд “Засгийн газрын Хүндэт өргөмжлөл” олгох Ерөнхий сайдын захирамжийн төсөл боловсруулан албажуулж холбогдох бусад арга хэмжээг авч ажиллав. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан 106 хүнийг шагнаж урамшуулах арга хэмжээг зохион байгуулав.<br>-“Засгийн газрын Хүндэт өргөмжлөл” шагналд нэр дэвшүүлэхтэй холбоотой мэдээлэл, танилцуулга бүхий албан бичгийг яамдад хүргүүлэв.<br>-Төрийн захиргааны албан хаагчдад тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн 238 албан хаагчийн мэдээллийг хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн цахим систем “ХНУМТ” дэх мэдээлэлтэй тулган баталгаажуулж, шаардлага хангасан албан хаагчдад зэрэг дэв олгох шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.<br>-Төрийн албаны зөвлөлөөс санаачлан зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” 6 бүс, нийслэлийн зөвлөгөөнд нэгжийн албан хаагчид зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахын зэрэгцээ зөвлөгөөнд оролцсон албан хаагчдын санал, тулгамдаж байгаа асуудалд дүн шинжилгээ хийж зөвлөгөөний нэгдсэн тайлан, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд тусгах саналыг боловсруулав.<br>-Төрийн албаны зөвлөлөөс санаачлан зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” бүсийн зөвлөгөөнд оролцсон албан хаагчдаас төрийн албаны нэр хүнд, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх, төрийн албаны сонгон шалгаруулалт, сургалт, хөгжил, шатлан дэвших асуудлыг зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төрийн албаны хүний нөөцийг мэргэжлийн өндөр ур чадвартай, хариуцлагатай, ёс зүйтэй албан | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчдаар бүрдүүлэх зэрэг олон санал, санаачилгыг гаргаж байсан бөгөөд нийтлэг хэд хэдэн асуудлыг нэн даруй шийдвэрлэж өгөхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад хандсан. Орон нутгийн албан хаагчдад тулгамдаж буй 13 нийтлэг асуудлыг шийдвэрлэх хүрээнд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 24 дүгээр хуралдааны тэмдэглэлийг Төрийн албаны зөвлөл, холбогдох яамдад хүргүүлэв. | |
| Стратегийн 7 дугаар зорилго: Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/, Шадар сайд /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Олимп, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны болон төсвийн шууд захирагчид төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, дотоод үйлчилгээг хариуцах, дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| Зорилт 7.1 | ТЕЗ-дын төсвийн төсөл, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, захиран зарцуулах, тайлагнах, хөндлөнгийн аудит хийлгэх, шилэн данс хөтлөх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулах | Үйл ажиллагааны зардлаар | Холбогдох хууль, журмын хүрээнд хэрэгжүүлсэн байх | Хуулийн хугацаанд тайланг нэгтгэж, төсөв төлөвлөгөөг боловсруулан хүргүүлсэн. | Холбогдох хуулийн хугацаанд нэгтгэн, тайлагнасан байна. | Холбогдох хуулийн хугацаанд нэгтгэн, тайлагнасан. | 91.3 |
| 7.1.1. | ТЕЗ-дын төсвийн багцын 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС 6-ийн 39-ийн дагуу гаргаж, ҮАГ-аар аудит хийлгэн, аудитлагдсан тайланг СЯ-нд хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | ТЕЗ-дын санхүүгийн тайланг хууль, журмын дагуу гаргаж СЯ, ҮАГ-т хуулийн хугацаанд тайлагнаж, аудитлагдсан эсэх | ТЕЗ-дын 2023 оны жилийн эцсийн болон 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж, аудитлуулсан. | Тоо хэмжээ:<br>-2 удаа,<br>-7 ТЕЗ-ийн 7 тайлан<br>Чанар: Төсвийн тухай хууль, НББт хууль, УСНББОУС хэрэгжсэн байна. | ТЕЗ–МУЕС, МУШС/БХОБ/, МУШС/ГХХО/, ЗГХЭГ, БСҮХ, 20МХҮХ, ХҮҮХ-ны даргын төсвийн багцын 2024.12.31-нээр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланг хууль, журмын дагуу гаргаж СЯ, ҮАГ-т хуулийн хугацаанд тайлагнасан. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас аудит хийж “Санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, | 95 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аргачлал, журмын дагуу материаллаг зүйлийн хувьд үнэн шударга илэрхийлсэн байна" гээд МУЕС, МУШС/ГХХО/, ЗГХЭГ, 20МХҮХ, БСҮХ-ны дарга -"ӨӨРЧЛӨЛТГҮЙ", МУШС/БХОБ/, ХҮҮХ-ны дарга - "ХЯЗГААРЛАЛТТАЙ" санал, дүгнэлт өгсөн болно.<br>2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хууль, журмын дагуу Сангийн яамны "Төсөвт байгууллагын тайлан-Э-тайлан" цахим системээр нэгтгэн, ТЕЗ дотроо болон ТЕЗ-ийн хоорондох устгах гүйлгээний бичилтийг хийн Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгүүлсэн.<br>Мөн ОНБТСҮХ-ны даргын хаалтын тайланг хийж, ҮАГ, СЯ-нд хүргүүлж, системд шивж оруулсан. | |
| 7.1.2 | ТШЗ-Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ болон бусад ажлын албадын санхүүгийн улирал, жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг гаргах, үр дүнг удирдлагуудад танилцуулах, санал боловсруулах, тайлан тэнцлийн дүнд шинжилгээ хийж, ҮАГ-т хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Нийт 10 байгууллагын ТШЗ-ийн санхүүгийн тайланг тайлагнасан эсэх | 6 ТШЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн тайланг ҮАГ-т хүргүүлэн аудит хийлгэсэн. | Тоо хэмжээ: -2 удаа, -жилийн эцэс, хагас жилийн тайлан,<br>-ТШЗ байгууллагууд;<br>Чанар: Төсвийн тухай хууль, НББт хууль хэрэгжсэн байна. | ТШ захирагчийн МУЕСТөсөв, ШС/БХОБАХ/, ШС/ГХО,ХАА/ ЗГХЭГ, НУБХАЗТБҮХ, БСҮХ, 20МҮХ, АХ2050ҮХ, ХҮҮХ, ОНБТСҮХ-ын ажлын албад, ЗГХЭГ-ын ХО их засвар, техник хяналт, барьцаа, ахмадын сан зэрэг 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг УСНББОУС, "Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар"-т нийцүүлэн гаргаж, удирдлагад танилцуулж, ҮАГ-т 2025 оны Х/61 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br>ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн улирлын болон жилийн эцсийн тайлан тэнцэл гаргахад шаардлагатай анхан шатны баримтууд, бэлэн мөнгөний тайлан, бараа материалын тайлан, хангамжийн материалын тайлан, үндсэн хөрөнгийн тайлан, цалин хөлс, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлан, харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлсэн акт, төрийн сан банкны болон арилжааны банкны үлдэгдэл, улсын төсвийн | 95 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, зохиогчийн болон хяналтын барьцаа дансны тооцоо зэргийг үнэн зөв, тооцоолж, хянаж тайлагнасан.<br>ТШЗ-ийн тайланд ҮАГ-аас түүврийн аргаар явцын болон жилийн эцсийн байдлаар аудит хийсэн бөгөөд түүнтэй уялдуулан шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайланг шуурхай, үнэн зөв гаргаж хамтран ажилласан. | |
| 7.1.3 | ТБОНӨХБАҮХАт хуулийн хүрээнд Ерөнхий сайд, Шадар сайд /БХОБ/, Шадар сайд /ГХХО/, ЗГХЭГ, БСҮХ, 20МХҮХ, ХҮҮХ-ны даргын багцуудын ХАА-ны 2025 оны төлөвлөгөө, 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн хуулийн хугацаанд СЯ-нд хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж СЯ-нд хүргүүлсэн эсэх | 7 багцын 2023 оны ХАА-ны ерөнхий тайлан, 2024 оны ерөнхий төлөвлөгөө, 2024 оны ХАА-ны эхний хагас жилийн тайланг нэгтгэж СЯ-нд хүргүүлсэн. | Тоо хэмжээ:<br>-7 ТЕЗ,<br>-7 төлөвлөгөө,<br>-7 тайлан.<br>Чанар: Холбогдох заавар журмын дагуу тайлагнасан байна. | ТЕЗ-дын 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн хуулийн хугацаанд гаргаж, МУЕС, ЗГХЭГ-ын даргын багцыг 2025.01.15-ны ХЭГ/123, МУШС/БХОБ/ 2025.01.15-ны ЗГ-2/73, МУШС /ГХХО/ 2025.01.07-ны ЗГ-3/31 20МХҮХ-ны даргын багцыг 2025.01.08-ны А/01 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, Шилэн данс болон худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн.<br>ТЕЗ-дын багцын 2025 оны худалдан авах ажиллагааны хагас жилийн явцын тайланг 2025.06.30-наар бэлтгэн хүргүүлэх болно.<br>ЗГХЭГ-ын даргын багцын 42 төсөл, арга хэмжээ, харьяа байгууллагын 17 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг жилийн эцсийн нэгтгэсэн байна. | 85 |
| 7.1.4 | ТШЗ-ийн 10 байгууллага болон ТЕЗ 7 багцын байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн ТЕЗ-ийн 2027-2028 оны төсвийн төсөөлөл, 2026 оны урсгал төсөв, хөрөнгө оруулалтын нэгтгэсэн төслийг хийж, удирдлагад танилцуулан албажуулж, СЯ-нд хүргүүлэн батлуулах | Үйл ажиллагааны зардлаар | Саналыг бодлогын баримт бичгүүд болон хууль, журамд нийцүүлэн хуулийн хугацаанд нэгтгэн СЯ-нд хүргүүлсэн эсэх | ТЕЗ 7 багцын байгууллагаас ирсэн саналыг хянаж, нэгтгэн СЯ-нд хүргүүлсэн. | Тоо хэмжээ: 7 багцын 7 нэгтгэл төсөв,<br>Чанар: Холбогдох хууль, журамд нийцсэн байна. | Төсвийн тухай хуулийн 8.3.1-т заасны дагуу ТЕЗ нар 2025.06.09-10-ны хооронд Сангийн сайдад 2026 оны төсвийн хязгаарын саналаа тус бүртээ хүргүүлсэн.<br>Мөн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу МУЕС, МУШС/БХОБ/, МУШС/ГХХО/, ЗГХЭГ, 20МХҮХ, БСҮХ, ХҮҮХ-ны даргын багцын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2026 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл, арга | 85 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний /зөвхөн барилга, байгууламж/ саналыг pimis.publicinvestment.gov.mn/ цахим системээр 2025.06.30-ны дотор авч, Сангийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 4-ны өдрийн 137-н тоот тушаалаар батлагдсан "Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урдчилсан үнэлгээний аргачлал"-аар үнэлгээ хийнэ. | |
| 7.1.5 | Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу ТЕЗ болон ТШЗ-ийн хөрөнгө оруулалт, ХАА, түүнтэй холбогдсон тайлан, төлөвлөгөө, гүйцэтгэлийг нийтэд хуулийн хугацаанд мэдээлэх | Үйл ажиллагааны зардлаар | Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн эсэх | ТЕЗ болон ТШЗ нарын төсөв, санхүүжилт, хөрөнгө оруулалт, ХАА, түүнтэй холбогдсон тайлан, төлөвлөгөө, гүйцэтгэлийг shilendans.gov.mn сайтад хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлсэн. | Тоо хэмжээ: Санхүүжилт, тайлан бүрээр<br>Чанар: Шилэн дансны тухай хууль, холбогдох журам хэрэгжсэн байна. | Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу shilendans.gov.mn цахим системд Төсвийн 7 ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсөв, санхүү, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны мэдээ, тайлан зэргийг нийтэд хуулийн хугацаанд 2025.06.10-ны өдрийн байдлаар нийт 420 /ТЕЗ тус бүр 70*6=420/ мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>Сангийн яамны Шилэн дансны статистик мэдээллээр 2024 онд ТЕЗ нар 86-100 хувийн гүйцэтгэлтэйгээр шилэн дансны мэдээллийг оруулсан гэж дүгнэгдсэн.<br>Төсвийн шууд захирагчийн байгууллагуудын 2025 оны төсөв, санхүү, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны мэдээ, тайлан зэргийг нийтэд хуулийн хугацаанд 2025.06.10-ны өдрийн байдлаар нийт 490 мэдээ, мэдээллийг байршуулсан болно. | 95 |
| 7.1.6 | Багцын байгууллагуудаас ирүүлсэн батлагдсан төсөвт зохицуулалт хийх болон санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг ТЕЗ-дад танилцуулан албажуулж, СЯ-нд хүргүүлэн шийдвэрлүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Саналыг хууль, журамд нийцүүлэн хуулийн хугацаанд тухай бүр шийдвэрлүүлэн СЯ-нд хүргүүлсэн эсэх | ТЕЗ-дын багцын байгууллагуудаас ирсэн саналыг тухай бүр нь хүргүүлж, шийдвэрлүүлсэн. | Тоо хэмжээ: 7 багцын төсөвт байгууллага тухай бүр,<br>Чанар: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад заавар журамд нийцсэн байна. | Нийт 7 ТЕЗ-ийн багцын байгууллагуудаас ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан батлагдсан төсөвт зохицуулалт хийхээр ирүүлсэн саналыг хянаж, Сангийн сайдад уламжлан тухай бүр шийдвэрлүүлэн ажилласан. **/МУЕС-14, МУШС/БХОБ/-13, МУШС/ГХХО/-7, ЗГХЭГ-8, нийт 42 төсвийн зохицуулалт хийх тухай албан бичиг, 2025 оны 6 сарын 10-ны байдлаар/** | 95 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.1.7 | ТЕЗ-дын ТГ-ийн болон өр, авлагын сарын мэдээг холбогдох багцын байгууллагуудын хэмжээнд нэгтгэн програмд шивэх, тайлбар тодруулгын хамт холбогдох байгууллагад хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээг хууль, журамд нийцүүлэн сар бүр СЯ-нд хүргүүлсэн эсэх | ТЕЗ-дын харьяа байгууллагын сар бүрийн ТГ, өр авлагын мэдээг шалган хүлээн авч нэгтгэлийг Фрийбаланс санхүүгийн програмд оруулж, ТГ-ийн мэдээг, тодруулгын хамт хуульд заасан хугацаанд нь хүргүүлсэн. | Тоо хэмжээ:Сар бүр, 7 багцын дүнгээр,<br>Чанар: Мэдээ үнэн зөв, цаг хугацаандаа гарч нэгтгэсэн байх, заавар журамд нийцсэн байна. | ТЕЗ-дийн төсөвт 160 гаруй байгууллагын сар бүрийн урсгал төсөв, нэмэлт, хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээг шалган хүлээн авч, байгууллага тус бүрийн санхүүжилтийн орлогыг хуваарилах 170, тодорхойгүй орлого хуваарилах 100 гаруй, нийт 270 орчим гүйлгээг Фрийбаланс програмд оруулсан.<br>ТЕЗ-дын байгууллагуудын сар бүрийн урсгал төсөв, нэмэлт, хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээг шалган хүлээн авч, Сангийн яамны холбогдох мэргэжилтэнтэй тулган баталгаажуулж, Төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэсэн.<br>/Нийт 7 ТЕЗ-ийн сар бүрийн 36 төсвийн гүйцэтгэлийн тайлан, ТШЗ-ийн сар бүрийн / | 90 |
| 7.1.8 | ТЕЗ-дын төсвийн багцын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, их засварын ажлын гүйцэтгэлд ҮАГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хагас, бүтэн жилээр биелэлтийг гарган ҮАГ-т хүргүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | ТЕЗ-ийн жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх | ТЕЗ-дын төсвийн багцын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг гарган хүргүүлсэн. | Тоо хэмжээ: ТЕЗ-ийн зөвлөмжийн биелэлтийн<br>-7 төлөвлөгөө, тайлан<br>Чанар: Акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжсэн байна. | Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ТЕЗ-даар батлуулан МУ-ын Ерөнхий аудиторт 2025.05.23-ны ХЭГ/1499, МУШС /БХОБ/ 2025.05.26-ны ЗГ-2/510, МУШС/ГХХО/ 2025.05.09-ний өдрийн ЗГ-3/308 БСҮХ-ны даргын тоот 2025 оны 01/749, 20МХҮХ-ны даргын 01/342, ХҮҮХ-ны даргын 2025.05.15-ны өдрийн 01/362 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Бүх ТЕЗ нарын хариуцсан ажилтнууд Үндэсний аудитын газрын www.sso.audit.mn цахим системд 2023 оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүрт оруулж, хянан баталгаажуулж, 2024 оны тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг шивж оруулсан. | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний аудитын газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт эцэслэн гараагүй байгаа болно.<br>Биелэлтийг тайланг 2025.09.30-ны дотор ҮАГ-т хүргүүлнэ. | |
| Зорилт 7.2 | ЗГХЭГ-ын эд хөрөнгийг хариуцан, дотоод үйлчилгээг эрхлэх | Үйл ажиллагааны зардлаар | Санхүүгийн үйлчилгээг холбогдох хууль, журмын хүрээнд хэрэгжүүлсэн байх | Төсвийн тухай хууль, ЗГХЭГ-ын Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн дагуу санхүүгийн үйлчилгээг үзүүлсэн. | Эд хөрөнгө хариуцах, дотоод үйлчилгээ холбогдох хууль, журмын дагуу хэрэгжсэн байна. | Эд хөрөнгө хариуцаж, дотоод үйлчилгээг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн. | 95 |
| 7.2.1 | ТШЗ /10 байгууллага/-ийн батлагдсан төсвийн дагуу санхүүжилт авч, үйл ажиллагааны болон урсгал зардлыг санхүүжүүлж, хууль тогтоомжийн дагуу санхүүгийн үйлчилгээ үзүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Санхүүжилтийг бүрэн авч, санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн байх | Төлбөрийн хүсэлтийг бэлтгэн, удирдлагаар хянан баталгаажуулж, е-баримтыг бүрдүүлэн гүйлгээ хийж харилцагч, бэлтгэн нийлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн. | Тоо хэмжээ: гүйцэтгэлээр,<br>Батлагдсан төсвийн хүрээнд ажил үйлчилгээ хэвийн явагдах нөхцөл бүрдсэн байна. | Ерөнхий сайдын төсөв, ЗГХЭГазрын харилцах дансаар хийгдэх төлбөр тооцоог удирдлагын өгсөн чиглэлийн дагуу төлбөрийн хүсэлт бэлтгэн 1, 2-р гарын үсгээр баталгаажуулан Сангийн яамны цахим төлбөрийн системээр 2074, бусад ТШЗ-ийн байгууллагын 312 гүйлгээ гаргаж, анхан шатны баримтын бүрдлийг шалгаж, урьдчилгаа, өглөг, авлагын тооцоог хийж ажилласан. /**нийт-2074+312=2386 төлбөрийн даалгавар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад /1120/ 113%-аар өссөн байна**/<br>Нярваас нийт 37 удаагийн кассын орлого, зарлагын тайланг хүлээн авч анхан шатны баримтын бүрдлийг шалган, бүртгэлд тусган ажилласан. | 95 |
| 7.2.2 | Цалин хөлс, НДШ, ХХОАТ, ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж, урамшуулал, ажиллагсдад олгох хоол, унааны хөнгөлөлтүүд, ажлаас халагдсаны тэтгэмжийг тооцох, татвар, нийгмийн даатгалын | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоог хууль, журамд нийцүүлэн ажилласан эсэх | Цалин хөлсийг сар бүр олгож, сар бүрийн 5-ны дотор нийгмийн даатгал, улирал бүр татварын | Цалин хөлс, НДШ, ХХОАТ, ээлжийн амралт, өвчтэй хугацааны тэтгэмж, урамшуулал, хоол, унааны хөнгөлөлтийг тооцсон байна. | ТЗУГ-аас гаргасан албан хаагчдын цагийн мэдээний дагуу цалин хөлсийг тооцож олгосон. Мөн албан хаагчдын ээлжийн амралтын тооцоог тухай бүр нь хийж олгосон. ТШЗ-ийн 10 байгууллагын албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, өвчтэй хугацааны тэтгэмжийн тооцоо, | 95 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудтай холбогдох тооцоог хийх, өр авлага үүсгэхгүй байх | | | байгууллагад тайлан гаргаж, тооцоо нийлэн, өр авлага гаргахгүй ажилласан. | | суутган тооцсон хувь хүний орлогын албан татварын тайланг хуульд заасан хугацаа бүрт гарган цахим системд шивж тайлагнасан. Татвар, нийгмийн даатгалын төвлөрүүлэх орлогыг хуулийн хугацаанд нь шилжүүлэн тайлагнаж, өглөг, авлага үүсгэхгүй байхад анхааран ажилласан байна. | |
| 7.2.3 | Өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг эрхэлж хөрөнгийн тооллого хийж тооцоо бодох ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгах | Үйл ажиллагааны зардлаар | Тооллогыг үнэн зөв хийн, тайлан тэнцэлд тусгасан эсэх | Тэргүүн дэд даргын тушаалаар жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комисс байгуулж, тооллого хийн үр дүнг 2023 оны санхүүгийн тайлан балансад тусгасан. | Тоо хэмжээ: 2 удаа,<br>Чанар: ТБОНӨтухай хууль, ННБтухай хууль хэрэгжсэн байна. | ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2024 оны 106 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хөрөнгийн тооллогын үр дүнг хянаж, тооллогоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг ТӨБЗГ-ын газрын 2024 оны А1/2386 тоот тогтоолоор ажлын албадын хөрөнгийг акталж, данснаас хасаж, мөн энэ оны 393, 529, 587, 640 тоот тогтоолоор үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх шийдвэрийг гаргуулж үр дүнг жилийн эцсийн тайланд тусгасан.<br>ТДД-ын тушаалаар эхний хагас болон жилийн эцсийн эргэлтийн хөрөнгийг тоолох тооллогын комиссын хамтаар төсвийн шууд захирагчийн 9 байгууллагын бараа материал, хангамжийн материал, үндсэн хөрөнгө зэрэг эргэлтийн хөрөнгийг тоолж баталгаажуулахаар ажиллаж байна. | 90 |
| 7.2.4 | Номтын аманд эрчим хүчний хэмнэлттэй төр захиргааны нэгдсэн байрыг барьж байгуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Арга хэмжээ үр дүнд хүрсэн байх | Ажлын хэсэг байгуулж ажилласан. | Үр дүнтэй арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна. | Номтын аманд эрчим хүчний хэмнэлттэй төр, захиргааны нэгдсэн байрны бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100 |
| Стратегийн 8 дугаар зорилго: Төрийн ёслолын дэг жаягийг тогтоож, түүнд оролцогчдын үйл ажиллагааг зохион байгуулах | | | | | | | |
| Зорилт 8.1 | Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Шадар сайд нарын үйл ажиллагааны ёслолын арга | Үйл ажиллагааны зардлаар | Төрийн ёслолын журам, дипломат ёслолын хэм хэмжээ практик, | Ерөнхийлөгчийн 136, УИХ-ын даргын 221, Ерөнхий сайдын 207, УИХ-ын дэд | Төрийн ёслолын журам, дипломат ёслолын практик, олон улсын харилцааны хэм хэмжээнд нийцүүлж, | Ерөнхийлөгчийн **25**,<br>УИХ-ын даргын **18**,<br>Ерөнхий сайдын **85**,<br>УИХ-ын дэд дарга нарын **10**, | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг холбогдох журмын дагуу эрхлэн явуулах | | олон улсын харилцааны хэм хэмжээнд нийцүүлсэн байх | дарга, Шадар сайд нарын 10 удаагийн, нийт 574 удаагийн үйл ажиллагааны ёслолыг зохион байгуулсан. | шуурхай зохион байгуулсан байна. | Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Шадар сайд нарын **10 нийт 148** удаагийн үйл ажиллагааны ёслолын арга хэмжээг зохион байгуулсан. | |
| 8.1.1 | Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Шадар сайд нар нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдээр зохиогдох төрийн ёслолын арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Холбогдох журам, дипломат ёслолын практик, олон улсын харил-цааны хэм хэмжээнд нийцүүлсэн байх | Нийт 9 баяр, 8 тэмдэглэлт өдрийн төрийн ёслолын ажиллагаанд Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Шадар сайд нар оролцоход зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авсан. | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасан өдрүүдээр зохион байгуулах төрийн ёслолын арга хэмжээнд Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Шадар сайд нар оролцоход тухай бүр бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Шадар сайд нар Цагаан сар, Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр, Хүүхдийн баяр, Үндсэн хуулийн өдөр, Монгол цэргийн өдөр зэрэг нийтээр тэмдэглэх баярын **3**, тэмдэглэлт өдрийн **2** төрийн ёслолын үйл ажиллагаанд оролцоход тухай бүр бэлтгэлийг хангаж, зохион байгуулан, зохицуулалт хийсэн. | 100 |
| 8.1.2 | Төрийн дээд цол, одон медаль болон бусад шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Тухай бүр шагнагдагчдад журмыг урьдчилан танилцуулж, тогтсон хэм хэмжээнд нийцүүлсэн байх | Ерөнхийлөгчийн төрийн цол, одон, медаль, цэргийн болон дипломат цол, Алдарт эхийн одон зэрэг нийт 19 удаагийн, шагнал гардуулах ёслолын ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, 5153 хүнд журмыг урьдчилан танилцуулж, зохион байгуулсан. УИХ-ын дарга Хөдөлмөрийн | Ерөнхийлөгч нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр төрийн цол, одон, медаль, цэргийн болон дипломат цол, Алдарт эхийн одон гардуулах, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар Төрийн ёслолын журамд заасан арга хэмжээнд шагнал гардуулах ёслолыг тухай бүр зохион байгуулсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгч нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр төрийн дээд цол, төрийн дээд шагнал, одон, медаль, цэргийн дээд цол, Алдарт эхийн одон зэрэг нийт **17** удаагийн шагнал гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулахад оролцож, шагнагдагчдад ёслолын журмыг урьдчилан танилцуулж тогтсон хэм хэмжээнд нийцүүлэн зохион байгуулсан болно | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | баатар Б.Чимэдийн нэрэмжит шагнал гардуулсан ёслол, Ерөнхий сайд олон улсад амжилт гаргасан хүүхдүүдэд батламж гардуулах ёслолыг тус тус зохион байгуулсан. | | | |
| 8.1.3 | Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Шадар сайд нар гадаад улсад айлчлах болон хөдөө орон нутагт ажиллахад дагалдан явж, ёслол хүндэтгэлийн асуудлыг зохицуулах | Үйл ажиллагааны зардлаар | Дипломат ёслолын практик, олон улсын харилцааны хэм хэмжээнд нийцсэн, орон нутагт зөвлөгөө өгч ажлаа уялдуулсан байх | Ерөнхийлөгчийн АНУ, БНХАУ, АНЭУ-д оролцсон чуулга уулзалт, БНФУ, БНСВУ БНАЛАУ-д хийсэн төрийн айлчлал, Ерөнхий сайдын БНСУ, БНХАУ, БНКирУ, АНУ-д хийсэн ажлын айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулсан. Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдыг орон нутагт ажиллахад ёслолын ажилтнууд тухай бүр урьдчилан очиж, бэлтгэл хангаж ажилласан. | Дипломат ёслолын практик, олон улсын харилцааны хэм хэмжээнд нийцүүлсэн байна.<br><br>Орон нутагт зөвлөгөө өгч, ёслолын асуудлыг зохицуулсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНПУ, БНЧУ, ОХУ-уудад хийсэн төрийн болон ажлын айлчлал хийхэд,<br>Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНХАУ-ын Харбин хотноо болох IX удаагийн Азийн өвлийн наадмын хаалтын ажиллагаанд оролцоход тус тус урьдчилан очиж, бэлтгэл ажлыг хангаж ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан.<br><br>Монгол Улсын Ерөнхийлөгч Төв, Дархан-Уул, Өвөрхангай аймгуудад,<br>УИХ-ын дарга Говь-Алтай, Ховд, Завхан, Увс, Хэнтий, Архангай, Дундговь аймгуудад,<br>Ерөнхий сайд Дархан-Уул, Архангай, Булган, Дорноговь аймгуудад ажиллахад батлагдсан хөтөлбөрийн дагуу ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж аймгуудын удирдлагуудад ёслолын асуудлаар зөвлөгөө өгч ажилласан болно. | 100 |
| 8.1.4 | Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Шадар сайд нарт гадаадын зочин төлөөлөгч бараалхах уулзалт, урилгаар ирэх гадаад орны зочид төлөөлөгчдийн айлчлалын | Үйл ажиллагааны зардлаар | Мэдүүлсэн уулзалтын биелэлтийн хувь | Гадаадын зочин төлөөлөгчидтэй уулзсан Ерөнхийлөгчийн 27, УИХ-ын даргын 75, ЕС- | Мэдүүлсэн уулзалт бүрийг тухай бүр холбогдох хууль, журмын хүрээнд цаг хугацаанд нь 100 хувийн биелэлттэй | Гадаадын зочин төлөөлөгчидтэй хийсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн **8**, УИХ-ын даргын **10**, Ерөнхий сайдын **17**, УИХ-ын дэд дарга нарын **19**, Шадар сайд нарын **24**, **нийт 78** уулзалтыг тухай бүр холбогдох журмын хүрээнд зохион байгуулсан | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэх, зохион байгуулах | | | ын 42, УИХ-ын дэд даргын 35 уулзалт, ШС-ын 101, нийт 280 удаагийн уулзалтыг холбогдох журмын хүрээнд зохион байгуулсан. | зохион байгуулсан байна. | Ерөнхийлөгчийн урилгаар БНАУ-ын Ерөнхийлөгч<br>Александр Ван Дер Беллен, гэргий Дорис Шмидауэр нарын төрийн айлчлал 05 дугаар сарын 25-28-ны өдөр,<br><br>Туркменистан Улсын Ерөнхийлөгч Сердар Бердымухамедовын төрийн айлчлал 06 дугаар сарын 01-02-ны өдөр тус тус Монгол улсад хийсэн төрийн айлчлал,<br><br>УИХ-ын даргын урилгаар БНСУ-ын Үндэсний ассамблейн дарга Ү Вон Шигийн 04 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалыг холбогдох журам, олон улсын нийтлэг хэм хэмжээ, үндэсний ёс заншил, соёлд нийцүүлэн бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулсан.<br><br>Мөн гадаад улсаас Монгол Улсад суух болон хавсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд нар Монгол Улсын Ерөнхийлөгчид “Итгэмжлэх жуух бичиг” барих ёслолын арга хэмжээ 04 дүгээр сарын 21-ний өдөр холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан. | |
| Зорилт 8.2 | Төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Тоо хэмжээ | Нийтээр тэмдэглэх 8 баяр, 5 тэмдэглэлт өдрийг тохиолдуулан 48, нийт 63 үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулан, дэмжлэг үзүүлж ажилласан. | Холбогдох хууль тогтоомжийн дагуу ёслолын ажиллагааг зохион байгуулсан байна. | Төрийн дээд, өндөр албан тушаалтнууд Цагаан сарын баярыг тохиолдуулан **7** арга хэмжээ, Олон улсын эмэгтэйчүүдийн өдрөөр **5**, Хүүхдийн баяраар **2**, Үндсэн хуулийн өдрөөр **3**, Монгол цэргийн өдрийн **4**, төрийн бусад арга хэмжээний **44** нийт **65** ёслолын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулсан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.2.1 | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн төрийн ёслолын арга хэмжээний нэгдсэн хуваарийг Төрийн ёслолын журамд заасны дагуу гарган удирдлагаар батлуулж, арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомж, үндэсний уламжлал, ёс заншилд нийцсэн байх | Нийт 48 арга хэмжээг Төрийн ёслолын журамд заасны дагуу зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажилласан. | Холбогдох хууль тогтоомжийн дагуу ёслолын ажиллагааг зохион байгуулсан байна. | Төрийн дээд, өндөр албан тушаалтнууд Цагаан сарын баярыг тохиолдуулан **7** арга хэмжээ, Олон улсын эмэгтэйчүүдийн өдрөөр **5**, Хүүхдийн баяраар **2**, Үндсэн хуулийн өдрөөр **3**, Монгол цэргийн өдрийн **4** **нийт 21** ёслолын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулсан. | 100 |
| 8.2.2 | Төрийн ёслолын бусад арга хэмжээг холбогдох журмын дагуу эрхлэн явуулах | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомж, үндэсний уламжлал, ёс заншилд нийцсэн байх | ЗГ-ын гишүүд шинээр томилогдсонтой холбогдуулан УИХ-д тангараг өргөх 3 удаагийн, ЕС-аас батламж гардуулсан 3, Төрийн тахилгат уулын тэнгэрийг тайсан 2 ёслол зэрэг 15 үйл ажиллагааны зохион байгуулалтад оролцож ажилласан. | Тухай бүр хууль тогтоомж, үндэсний уламжлал, ёс заншилд нийцүүлэн зохион байгуулсан байна. | Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг Сас хооронд байгуулах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ,<br><br>Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат агсанд хүндэтгэл үзүүлэх Төрийн ёслолын арга хэмжээ,<br><br>УИХ-ын хаврын чуулганы нээлтийн ёслолын арга хэмжээ,<br><br>“Аугаа их Ялалтын баярын 80 жил”-ийн ойн арга хэмжээ,<br><br>"Тогтвортой байдлын яриа хэлэлцээ - Уур амьсгалын өөрчлөлт: Тэрбуман мод” олон улсын чуулга уулзалт зэрэг **нийт 44** арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. | 100 |
| 8.2.3 | Төрийн дээд, өндөр албан тушаалтнуудад ёслолын үйл ажиллагааны бэлэг дурсгалын зүйлс бэлдэх | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомж, үндэсний соёл, онцлогийг шингээсэн, ёс заншилд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан байх | Нийт 3574 бэлэг Санхүүгийн тайланг сар, улирлаар эх материалыг үндэслэн “Interactive programme”-д оруулж орлого, зарлагын тайланг СЭЗГ-т гаргаж өгсөн. | Тухай бүр хууль тогтоомж, үндэсний соёл, онцлогийг шингээсэн, ёс заншилд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан бэлэг дурсгалын зүйлсийг бэлдсэн байна. | Санхүүгийн тайланг сар, улирлаар эх материалыг үндэслэн “Interactive programme”-д оруулж орлого, зарлагын тайланг СЭЗГ-т гаргаж хүргүүлсэн | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2024 он) | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.2.4 | Төрийн ёслолын газар дахь бүртгэл, судалгааны хөтлөлтийг нарийн чанд болгох | Үйл ажиллагааны зардлаар | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Төрийн ёслолын арга хэмжээний тэмдэглэл, уулзалт, урилга, мэндчилгээ, бэлэг дурсгалын зүйлс, явуулсан, ирсэн бичиг, эмгэнэлийн бичгийг он дараалаар бүртгэсэн. | Судалгаа, бүртгэл, тэмдэглэл хөтлөлтийг он дарааллаар ангилан ялгаж төрөлжүүлэн хөтөлсөн байна. | Ёслолын тэмдэглэл – **1**<br><br>Эмгэнэлийн бичиг – **7**<br><br>Төрийн туганд хүндэтгэл үзүүлэх зөвшөөрөл – **171**<br><br>“Чингис хаан” нисэх онгоцны буудлын ВИП танхимаар үйлчлүүлэх зөвшөөрөл - **497**<br><br>Төрийн ордонд гадаадын зочид, төлөөлөгчидтэй хийсэн уулзалт - **574**<br><br>Ирсэн урилга, мэндчилгээ, бэлэг дурсгалын зүйлс – **33**<br><br>Тус тус дарааллын дагуу, ангилан бүртгэсэн. | 100 |
| Стратегийн 9 дүгээр зорилго: Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр тогтмол хангах, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, Ерөнхий сайдын хэлэх үгийн төслийг бэлтгэх | | | | | | | |
